



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/119

Арвайхээр сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох,  
тендер хүчингүй болгож, дахин зарлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 30 дугаар зүйлийн 30.1.3, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 11 дүгээр зөвлөмжийн дагуу аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газарт 2023 онд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх тендерийн 4 дүгээр багц Амьсгалын эрхтэн тогтолцоо, харшлын шинж тэмдэгт нөлөөлөх эм бэлдмэлүүдийг 22,446,080 (хорин хоёр сая дөрвөн зуун дөчин зургаан мянга наяд) төгрөгөөр Монфа трейд ХХК-иар, 11 дүгээр багц Резинэн эдлэл, ороох боох материалыг 8,745,620 (найман сая долоон зуун дөчин таван мянга зургаан зуун хорь) төгрөгөөр Сүвэн Уул ХХК-иар, 13 дугаар багц Зүү тариурыг 102,306,550 (нэг зуун хоёр сая гурван зуун зургаан мянга таван зуун тавь) төгрөгөөр Мөнхийн тун ХХК-иар тус тус гүйцэтгүүлсүгэй.

2.Дээрх шалгарсан багцуудад гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авч, гэрээний хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв)-т зөвшөөрсүгэй.

3.Тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүдийн бараа нийлүүлэлтийн чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, гарсан зөрчлийг тухай бүр арилгаж тайланг нэгтгэн танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Сайнжаргал)-т даалгасгай.

4.Шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн болон оролцогч ороогүй 1 дүгээр багц Сэтгэц нөлөөт, сэтгэл заслын эм бэлдмэлүүд, 2 дугаар багц Халуун бууруулах, өвчин намдаах эм, 3 дугаар багц Зүрх судас, тархины цусан хангамжид нөлөөлөх эм, 5 дугаар багц Хоол боловсруулах эрхтэн тогтолцоонд нөлөөлөх эм, 6 дугаар багц Нөхөн үржихүйн эм бэлдмэлүүд, 7 дугаар багц Амин дэм, 8 дугаар багц Дотоодод үйлдвэрлэгдсэн эм, 9 дүгээр багц Дотоодод үйлдвэрлэгдсэн тарилгын уусмал, 10 дугаар багц Эмнэлгийн хэрэгсэл, 12 дугаар багц Ариутгал, халдваргүйтэлийн бодис багцуудыг тус тус хүчингүй болгосугай.

5.Дээрх хүчингүй болсон багцуудыг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулахыг Үнэлгээний хороо (З.Балданням)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0196

D:My Doc. Zahiramj. Zasag darga